

ИНСУРТЕК ГЭЖ ЮУ ВЭ?



Инсуртек гэдэг нь даатгал болон технологи гэсэн үгнүүдийн хослолоос бүрдсэн нэршил бөгөөд технологид суурилсан даатгалын үйлчилгээг инсуртек гэж нэрлэнэ.

ИНСУРТЕКИЙН САЛБАРЫН ГОЛЛОХ ТРЕНД



Дижитал хэрэглэгчийн үйлчилгээ:

Технологийн дэвшил нь хэрэглэгчид даатгалын үйлчилгээг худалдан авах, нөхөн төлбөр нэхэмжлэх зэрэг бүхий л харилцааг цахимаар гүйцэтгэх боломжийг олгож байна.



Блокчэйд суурилсан аюулгүй байдлын баталгаажуулалт:

Даатгалын гэрээ, нөхөн төлбөрийн нэхэмжлэл, гүйлгээг блокчэйн дээр аюулгүй, ил тодоор гүйцэтгэн, хадгалах боломжтой.



Эрсдэлийн үнэлгээ:

Ахисан түвшний өгөгдлийн шинжилгээ, их өгөгдөл, хиймэл оюун ухааны тусламжтайгаар даатгалын эрсдэлийг илүү тодорхой үнэлэх боломж бүрдсэн.



Чатбот болон хиймэл оюун ухааны туслах:

Хиймэл оюун ухаанд суурилсан чатботууд нь хэрэглэгчид 24/7 горимоор тусламж үзүүлэн, шаардлагатай асуултад нь хариулна.



Телематикс болон юмсын интернэт:

Тээврийн хэрэгсэл болон бусад төрлийн өргөн хэрэглээний төхөөрөмж дэх зайнаас мэдээлэх төхөөрөмжийн тусламжтайгаар бодит цагийн горимоор өгөгдлийг цуглуулах боломж бүрдэж буй бөгөөд ингэснээр хэрэглэгч тухай бүрд тохирсон даатгалын бүтээгдэхүүнийг санал болгох боломжтой.



P2P даатгал:

Инсуртек нь заавал хэн нэгэн даатгагчид хандалгүйгээр хэрэглэгчид өөрсдөө бүлэг үүсгэн эрсдэлээ тархах байдлаар нэг нэгнийгээ даатгах боломжийг бүрдүүлж байна.




Нөхөн төлбөрийн автоматжуулалт:

Автоматжуулалт нь нөхөн төлбөр нэхэмжлэх процессыг түргэсгэн, бичиг цаасны ажлыг бууруулах, хэрэглэгчийн сэтгэл ханамжийг нэмэгдүүлэх боломжийг олгож байна.



Инсуртекийн зах зээл 2022 онд 5.48 тэрбум ам.доллаароор хэмжигдэж буй бөгөөд 2030 он гэхэд тус зах зээлийн хэмжээ 146.43 тэрбум ам.долларт хүрнэ гэсэн тооцоолол байна.



Сонирхуулахад 2017 онд **“Лемонадь”** даатгалын компанийн **хиймэл оюун ухаан болон чатботын хослол бүхий инсуртекийн үйлчилгээ** даатгуулагчийн нөхөн төлбөрийг ердөө **ГУРВАН** секундйн дотор шийдвэрлэж даатгалын салбарт рекорд тогтоож байжээ.